



“УЛААНБААТАР ХИВС” ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН**

**Улаанбаатар
2023 он**

“УЛААНБААТАР ХИВС” ХК

| НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | | | | | |
|---|---|---|---|------|------|
| ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна | | | | | |
| № | Зүйл | Хэрэгжилт | Тайлбар | Оноо | Хувь |
| 1 | <i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i> | Компани нь “Улаанбаатар хивс” ХК-ийн дүрмийн 7-р бүлгийн МУ-ын Б хэсэгт ТУЗ болон түүний дарга, гишүүдийн чиг үүрэг, хариуцлагыг /МУ-ын “Компанийн тухай хууль”-ийн хуульд зааснаас гадна/ зааж өгсөн. Харин ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийвчлан заасан зүйл дээрх дүрэмд ороогүй тул “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д нарийвчлан зааж өгсөн. Уг журмыг компанийн www.mongolia-carpet.mn сайтад байршуулсан болно. | “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг шинээр боловсруулж, компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 2 | <i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i> | Компанийн ТУЗ нь 2022 оны 4-р сарын 28-ны хурлын тогтоол №05/2022-оор ТУЗ-ийн хороодын гишүүдийг шинээр сонгож, баталсан. “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм” болон “Залгамж халааны бодлого”-ыг боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. Эдгээр журам, дүрмийг компанийн www.mongolia-carpet.mn сайтад байршуулсан болно. | “Компанийн ТУЗ-ийн “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм” ба “Залгамж халааны бодлого”-ыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 3 | <i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i> | ТУЗ-ийн гишүүдийн дэлгэрэнгүй/эзэмшдэг хувьцааны тоо, хараат бус байдал гэх мэт/ анкетыг жил бүр шинэчлэн, үйл ажиллагааны тайланд тусгаж, брошюр хэвлэн, хувьцаа эзэмшигчдэд түгээхээс гадна компанийн www.mongolia-carpet.mn website-д байршуулдаг. | | 2 | |
| 4 | <i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага</i> | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04-р сарын 28-ны №05/2022 тоот тогтоолоор “Нэр дэвшүүлэх хороо”, “Аудитын хороо”, “Цалин урамшууллын хороо”-дын бүтэц, чиг үүргийг тус тус баталсан ба 3 хороо тус бүрийн дүрэм болон бодлогыг шинэчлэн боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. . Эдгээр дүрэм, бодлогыг компанийн www.mongolia-carpet.mn сайтад байршуулсан болно. | “Компанийн ТУЗ-ийн хороодын дүрэм, бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |

| | | | | | |
|--|--|---|---|----|--|
| | <i>болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i> | | | | |
| 5 | <i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i> | ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн даргыг анх томилогдоход МҮХАҮТ-ын дэргэдэх сургалтын төвийн Компанийн засаглалын сургалтанд 100 % хамруулсан ба МХБ болон СЗХ-ноос зохион байгуулсан сургалтуудад 1-2 гишүүдийг тогтмол хамруулдаг. | | 2 | |
| 6 | <i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i> | Компани нь “Улаанбаатар хивс” ХК-ийн дүрэмд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан заалт байхгүй тул “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д тусгаж өгсөн. Уг журмыг компанийн www.mongolia-carpet.mn сайтад байршуулсан болно. | “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол №06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| ДҮН | | | | 12 | |
| ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ | | | | | |
| ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ | | | | | |
| 7 | <i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зоринo.</i> | Одоогоор ТУЗ-ийн гишүүдийн 33,33% буюу 3 гишүүн нь хараат бус байна. | Цаашид хараат бус гишүүдийн тоог нэмэх чиглэл барина. | 2 | |
| 8 | <i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i> | Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгогдсон байдаг. “Аудитын хорооны дүрэм” ба “Аудит ба эрсдлийн бодлого” баримт бичгийг боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. | “Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүрэм болон бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол №06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |

| | | | | | |
|--|---|---|--|----|--|
| 9 | 2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамишууллын хороо нь цалин, урамишууллын үйл ажиллагааны журам, цалин урамишууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамишууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамишууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно. | Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгогдсон байдаг. “Цалин, урамишууллын хорооны дүрэм” ба “бодлого”-ыг боловсруулж ТУЗ-өөр балуулсан. Хорооноос цалин урамшууллын талаарх асуудалд компанийн санхүүгийн албанаас оролцуулж судалгаа, мэдээлэл авч зөвлөлддөг. | “Компанийн ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны дүрэм болон бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 10 | 2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. | Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгогдсон байдаг. “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм” ба “Залгамж халааны бодлого”-ыг боловсруулж ТУЗ-өөр балуулсан. | “Компанийн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дүрэм болон бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023-оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 11 | 2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна. | Одоогоор ТУЗ-ийн дэргэд бусад хороо, түр хороо байгуулах шаардлага гараагүй тул байгуулж байгаагүй. ТУЗ-ийн дэргэд “Цалин урамшууллын хороо”, “Аудитын хороо” ба “Нэр дэвшүүлэх хороо” гэсэн үндсэн 3 хороотой ажилладаг. Түүнчлэн “Компанийн ёс зүйн журам”-ын 11-р зүйлд “Компанийн ёс зүйн хороо”-той байхаар тусгаж, эрх үүрэг, хариуцлага, бүтэц бүрэлдэхүүнийг з ааж өгсөн. | | 2 | |
| ДҮН | | | | 10 | |
| ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ | | | | | |
| ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана | | | | | |
| 12 | 3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | Компанийн шинээр боловсруулсан “Ёс зүйн журам”-ын 6-р бүлэг: ”Мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах” бүлгээр зохицуулах ба “Компанийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулах болно. | Компанийн “Мэдээллийн ил тод байдлын тухай журам”-ыг боловсруулан, ТУЗ-ийн 2023 оны 2-р улирлын хурлаар энэ дүрэм ба бодлогыг батлуулан мөрдөнө . | 1 | |

| | | | | | |
|---|--|--|---|---|--|
| 13 | 3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ. | Кодексын дагуу боловсруулсан 3 хорооны дүрэм бодлого, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм зэрэг 8 баримт бичгүүдийг Батлуульж компанийн www.mongolia-carpet.mn website-д байршуулж, олон нийтэд хүргэж байна.. | -“- | 2 | |
| 14 | 3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна. | Компанийн шинээр боловсруулсан “Ёс зүйн журам”-ын 6-р бүлэг:”Мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах” болон 7-р бүлэг:”Шударга ёс, ил тод байдлыг хангах” бүлгүүдэд компанийн үйл ажиллагааны зорилт, зорилгуудаа биелүүлэх бодлого болон үнэлгээ, тайлагналын талаар тусгасан. | | 1 | |
| ДҮН | | | | 4 | |
| ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана | | | | | |
| 15 | 4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | Шинээр боловсруулсан “Аудитын хорооны дүрэм”-д эдгээр асуудлуудыг тусгасан. | “Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүрэм болон бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023-оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 16 | 4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна. | Хөндлөнгийн аудитор нь өөрөө болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөө жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж, мэдээлэл өгдөг. | | 2 | |
| 17 | 4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг | Компани дээр “Дотоод аудитын журам” хэрэгжиж, дотоод аудитын хороо нь графикийн дагуу үзлэг шалгалт явуулж, мэдээлэх, засах үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагаа тогмолжсон. Мөн “Улаанбаатар | | 2 | |

| | | | | | |
|--|--|--|---|---|--|
| | <i>компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i> | хивс” ХК-ийн дүрэм”-ийн 8-р бүлгийн Б хэсэг буюу “Хянан шалгах зөвлөл” заалтад энэ асуудал туссан байгаа. | | | |
| ДҮН | | | | 6 | |
| ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА | | | | | |
| ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина | | | | | |
| 18 | <i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i> | Компани одоогоор эрсдлийн удирдлагын бүтэцгүй байгаа . “Аудит ба эрсдлийн бодлого” баримт бичгээр энэ асуудлыг зохицуулна. | Эрсдлийн удирдлагын хорооны чиг үүргийг Аудитын хорооны чиг үүрэгтэй нэгтгэсэн. | 2 | |
| 19 | <i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i> | Одоогоор ТУЗ-ийн дэргэдэх “Аудитын хороо”-ны чиг үүрэгт эрсдлийн удирдлага багтдаг ба уг хороо 3 гишүүнтэй, дарга нь хараат бус гишүүн байдаг. “Аудитын хорооны дүрэм”- ээр мэдээлэх, тайлагнах үйл ажиллагаа явагдана. | | 1 | |
| 20 | <i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i> | Компани нь “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ”-г хуульд заасны дагуу хийлгэж мөрддөг ба уг үнэлгээнд туссан эрсдлийг удирдах зөвлөгөөг баримтлан ажилладаг. Мөн “Компанийн ёс зүйн журам”-ын 8-р бүлэг “Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа” бүлэгт эдгээрийг тусгасан болно. - Үйл ажиллагаандаа Олон улсын байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO:14001:2015 стандарт болон | | 2 | |

| | | | | | |
|--|--|---|---|---|--|
| | | - Олон улсын Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 45001:2018 стандартыг тус тус нэвтрүүлэх зорилго тавьсан. | | | |
| 21 | 5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина. | “Компанийн ёс зүйн дүрэм”-ээр ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийг мэдээлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, сонирхлын зөрчлийг зохицуулах, бэлэг хүлээн авах, бэлэглэх харилцаа зэрэг комплайнс-ын хяналтыг тусгасан. | Цаашид комплайнсын хяналтын зааврыг нарийвчлан боловсруулах шаардлагатай. | 1 | |
| ДҮН | | | | 6 | |
| ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна | | | | | |
| 22 | 6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална. | ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, бусад хангамжийн асуудлыг ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж тогтоол гаргадаг. | | 2 | |
| 23 | 6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана. | ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал нь: суурь цалин+хуралд оролцсоны урамшуулал+бусад гэсэн бүтэцтэй байдаг. “Цалин урамшууллын бодлого”-д тусгасан. Мөн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д тусгасан. | “Компанийн ТУЗ-ийн “Цалин урамшууллын хорооны дүрэм” ба бодлогыг компанийн ТУЗ-ийн 2023-02-16-ны өдрийн хурлын тогтоол № 06/2023 -оор батлуулан мөрдөж эхэлсэн. | 2 | |
| 24 | 6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана. | “Компанийн дүрэм” болон ТУЗ-ийн дэргэдэх “Цалин урамшууллын хорооны дүрэм”-д тусган хэрэгжүүлж байна. | | 1 | |
| ДҮН | | | | 5 | |
| ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|--|
| 25 | 7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийн 4-р бүлэг: “Оролцогч талуудын харилцах харилцаа” бүлгээр оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, үйл ажиллагааг зохицуулна. | | 1 | |
| 26 | 7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана. | “Компанийн ёс зүйн журам”-ын 4-р бүлэг болох “Оролцогч талуудын харилцах харилцаа” бүлгээр зохицуулна. | | 2 | |
| 27 | 7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна. | Компанийн www.mongolia-carpet.mn website бүх талуудад нээлттэй ажиллаж байгаа. | | 2 | |
| 28 | 7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна. | “Компанийн дотоод журам” ажилтнуудын санал хүсэлтийг “Санал хүсэлт, гомдлын хайрцаг” ба “Зөрчлийг мэдээлэх хайрцаг” ажиллуулан хүлээн авч, компанийн дотоод журам, компанийн жил тутмын “БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ”-нд тусгадаг. | | 2 | |
| ДҮН | | | | 7 | |
| НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ | | | | | |
| ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно | | | | | |
| 29 | 8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийг 12 бүлэг, 1 хавсралттайгаар, зохих зааврын дагуу боловсруулсан. Уг дүрмийн 2-р бүлэг: “Эрхэм зорилго, үнэт зүйл, ёс зүйн зарчим” бүлэг үндсэн зорилтуудыг тогтоож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийг боловсруулж. ТУЗ-ийн 2023 оны 2-р 16-ны хурлаар хэлэлцүүлж, № 06/2023 | 2 | |

| | | | | | |
|--|--|--|------------------------------------|---|--|
| | <i>мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i> | | тогтоолоор батлуулан мөрдөж байна. | | |
| 30 | <i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i> | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийн 10-р бүлэг: “Ёс зүйн зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх” ба 11-р бүлэг: “Ёс зүйн хороо” бүлгүүдээр энэ асуудлыг зохицуулж, “Ёс зүйн зөрчлийг мэдээлэх хайрцаг” ажиллуулах гэх мэт тогтолцоотой. | -“- | 2 | |
| 31 | <i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i> | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийн 5-р бүлэг: “Ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд ажиллах” ба 9-р бүлэг: ”Засгийн газар, улс төр, шашны харилцаа” бүлгүүдээр зохицуулсан. | -“- | 2 | |
| ДҮН | | | | 6 | |
| ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ | | | | | |
| Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана | | | | | |
| 32 | <i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i> | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийн 4-р бүлэг: “Оролцогч талуудын харилцах харилцаа” бүлгээр зохицуулдаг. | | 2 | |
| 33 | <i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i> | Компанийн албан ёсны mail хаяг болох ubcarpet@gmail.com хөрөнгө оруулагчидтай харилцдаг. | | 2 | |
| 34 | <i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i> | Компанийн website www.mongolia-carpet.mn –аар болон жил бүр хэвлэдэг үйл ажиллагааны тайлан-брошюраар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч, санал хүсэлтээ өгөх боломж олгодог. | | 2 | |
| 35 | <i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх</i> | Компанийн website www.mongolia-carpet.mn –аар болон жил бүр хэвлэдэг үйл ажиллагааны тайлан-брошюраар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг. Зарим хувьцаа | | 2 | |

| | | | | |
|-------------|---|--|---|----|
| | эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна. | Эзэмшигчдэд хуралд оролцох урилгыг утсаар нь илгээх болон ХЭХ-аас өмнө утсаар, санал хүсэлтээ өгөх боломж олгодог. | | |
| 36 | 9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ. | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийн 5-р бүлэг: “Ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахуулиас ангид, хуулийн хүрээнд ажиллах” бүлгээр зохицуулсан. | “Компанийн ёс зүйн дүрэм”-ийг ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 16-ны хурлаар хэлэлцүүлж, № 06/2023 тогтоолоор батлуулан мөрдөж байна. | 2 |
| ДҮН | | | | 10 |
| НЭГДСЭН ДҮН | | | | 66 |

Тайлан бичсэн: “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Н.Батцэцэг